



## ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

1. Та аль тасагт хэвтэн эмчлүүлж байна вэ?




2. Эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш хэдий хугацааны дараа эмнэлэгт хэвтсэн бэ?




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 94% нь эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш 1-7 хоногийн дотор эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

3. Таны хэвтэн эмчлүүлж байгаа өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээг үнэлнэ үү.




Хэвтэн эмчлүүлэгчдийн 75% нь өрөө тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ маш сайн буюу сайн гэж үнэлсэн бол 22% нь дунд зэрэг, 3% нь муу гэж үнэлсэн байна.

4. Таны хэвтэн эмчлүүлж байгаа өрөө, тасалгаа дулаан, тухтай эсэхийг үнэлнэ үү



Өрөөний дулаан тухтай байдлыг үнэлнэ үү гэсэн асуултад 75% нь маш сайн буюу сайн, 24% нь дунд зэрэг, 1% нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

#### 5. Эмнэлгийн хоолны амт, чанарыг үнэлнэ үү.




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 70% нь эмнэлгийн хоолны амт чанар маш сайн буюу сайн байна гэж үнэлсэн бол 23% нь дунд зэрэг, 5% нь муу гэж үнэлсэн байна.

#### 6. Эмч, сувилагч нар Тантай хүндэтгэлтэй харьцсан уу?




Эмч сувилагч нарын харилцаа хандлагын асуултад 92% маш сайн буюу сайн, 7% нь дунд зэрэг, 1% нь муу гэсэн үнэлгээтэй байна.

#### 7. Эмнэлэгт хэвтэх хугацаанд Танд хийж буй эмийн эмчилгээний болзошгүй гаж нөлөөний талаар ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү?




Хэвтэн эмчлүүлэгчдийн 73% нь эмийн эмчилгээний болзошгүй гаж нөлөөний талаар маш сайн тайлбарлаж өгсөн гэж хариулсан байна.

8. Сувилагч нар Танд хийж буй эмчилгээ, ажилбарын талаар ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү?



Танд хийж буй эмчилгээ, ажилбарын талаар ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү гэсэн асуултад 77% нь маш сайн тайлбарлаж өгсөн гэж хариулсан бол 20% нь хагас дутуу тайлбарлаж өгсөн гэж хариулсан байна.

9. Танд эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авхуулсан эсэх?




Судалгаанд хамрагдсан хэвтэн эмчлүүлэгчдийн 73% нь эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авхуулаагүй гэж хариулсан бол 27% нь тийм гэж хариулсан байна.

Эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авсан гэж хариулсан хүмүүс нийт 861,000 төгрөгний эм тариаг гаднаас авсан байна.



10. Эмнэлэгт хэвтэх хугацаанд Танд үзүүлж буй тусламж, үйлчилгээнд Та хэр сэтгэл хангалуун байгаа вэ?



Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 83% нь эмнэлэгт хэвтэх хугацааны ерөнхий сэтгэл ханамж маш сайн буюу сайн 14% нь дунд зэрэг, 3% нь муу гэж хариулсан байна.

#### Судалгааны ерөнхий дүгнэлт

2023 оны 11-р сарын 13-ны өдөр Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр хэвтэн эмчлүүлж байгаа 100 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Нийт судалгаанд хамрагдсан хэвтэн эмчлүүлэгчдээс тухайн хэвтэж буй өрөө тасалгааны цэвэрлэгээ, дулаан тухтай байдлын талаарх асуултад 75% нь маш сайн буюу сайн гэж хариулсан бол 23% нь дунд зэрэг, 2% нь муу гэсэн үнэлгээ өсөн. Эмнэлгийн хоолны амт чанарын асуултад 70% маш сайн буюу сайн, 23% нь дунд зэрэг, 3% нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Эмч сувилагч нарын харилцаа хандлагын талаарх асуултад 92% маш сайн буюу сайн, 7% нь дунд зэрэг, 1% нь муу гэсэн үнэлгээ өгсөн. Эмч сувилагч нарын эмчилгээ, ажилбар, эмийн эмчилгээнд гарч буй гаж нөлөөний талаарх асуултад 75% нь маш сайн тайлбарлаж өгсөн, 19% нь хагас дутуу тайлбарлаж өгсөн, 4% нь огт тайлбарлаж өгөөгүй гэж хариулсан. Эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг 73%

нь гаднаас авхуулаагүй гэж хариулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр хэвтэн эмчлүүлж байгаа судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн ерөнхий сэтгэл ханамж 83% нь маш сайн буюу сайн, 14% нь дунд зэрэг, 3% нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.


### ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

1. Та БОЭТ-д ирж үйлчлүүлэхдээ анхан шатны эрүүл мэндийн төвөөр дамжиж ирсэн үү?




БОЭТ-ийн амбулаториор үйлчлүүлж байгаа судалгаанд оролцсон иргэдийн 35% нь анхан шатны эмнэлгээс лавлагаа шатны эмнэлэгт ирж үйлчлүүлж буй иргэд байна.

2. Та үзлэгийн цагаа хэрхэн авсан бэ?



Судалгаанд хамрагдсан нийт амбулаториор үйлчлүүлэгчдийн 52% нь үзлэгийн цагаа утсаар авсан байна.

3. Та цахим бүртгэлээс авсан товлосон хугацаандаа үзүүлж чадсан уу?




Амбулаториор үйлчлүүлж буй иргэдийн 65% нь цахим бүртгэлээс авсан товлосон цагтаа үзүүлж чадаагүй байна.




Амбулаториор үйлчлүүлж буй иргэдийн 65% нь цахим бүртгэлээс авсан товлосон цагтаа үзүүлж чадаагүй 10минутаас 2 цаг хүртэл хүлээсэн гэж хариулсан байна.

4. Эмч үзлэг хийхдээ Танд хэдэн минут зарцуулсан бэ?




Судалгаанд хамрагдсан иргэдийн 78% нь эмч үзлэг хийхдээ 15 минутаас их хугацаа зарцуулсан гэж хариулсан байна.

5. Эмч, сувилагч нар Тантай хүндэтгэлтэй харьцсан уу?




Эмч сувилагч нарын харилцаа хандлага сайн гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 60% нь маш сайн буюу сайн, 38% нь дунд зэрэг, 2% нь муу гэж үзсэн байна.

6. Эмч нар танд үзлэг эмчилгээний талаар ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү?



Судалгаанд хамрагдсан иргэдийн 58% нь эмч үзлэг эмчилгээний талаар маш ойлгомжтой тайлбарлаж өгсөн, 39% нь хагас дутуу тайлбарлаж өгсөн, 3% нь огт тайлбарлаж өгөөгүй гэж хариулсан байна.

7. Хүлээлгийн хэсгийн орчин тав тухтай байсан уу?




Хүлээлгийн хэсгийн орчин тав тухтай байсан уу гэсэн асуултад 35% нь маш сайн буюу сайн, 59% нь дунд зэрэг, 6% нь муу гэж хариулсан байна.

8. Танд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж, бэлэг авдаг эсэх?



Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 96% нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж авдаггүй гэж хариулсан байна.

9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд өгөх Таны ерөнхий сэтгэл ханамж ямар байна вэ?



БОЭТ-ийн амбулаториор үйлчлүүлж буй судалгаанд хамрагдсан иргэдийн 84% ерөнхий сэтгэл ханамж маш сайн буюу сайн гэж үнэлсэн байна.


#### Судалгааны ерөнхий дүгнэлт

2023 оны 11-р сарын 15-ны өдөр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаториор үйлчлүүлж байгаа 100 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн 65% нь лавлагаа шатны эмнэлэгт шууд ирж үйлчлүүлж байгаа бол 35% нь анхан шатны эмнэлгээс лавлагаа шатны эмнэлэгт ирж үйлчлүүлж байсан. Амбулаториор үйлчлүүлж буй иргэд үзлэгийн цагаа 52% нь утсаар, 36% нь өөрийн биеэр, 12% нь цахимаар авдаг байна. Цахим бүртгэлээс авсан товлосон цагтаа 65% нь үзүүлж чадаагүй ба 10 минутаас 2 цаг орчим хүлээдэг гэж хариулсан. Эмч сувилагч нарын харилцаа хандлагын талаар асуултад 60% нь маш сайн буюу сайн, 38% нь дунд зэрэг, 2% нь муу гэж хариулсан бөгөөд эмч нар үзлэг хийхдээ 15 минутаас их хугацаа зарцуулдаг гэж 78%, үзлэг эмчилгээний талаар маш ойлгомжтой тайлбарлаж өгдөг гэж 58% нь хариулсан байна. Хүлээлгийн хэсгийн орчны тав тух 35% нь маш сайн буюу сайн, 59% нь дунд зэрэг, 6% нь муу, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шан харамж авдаггүй гэж нийт судалгаанд оролцогчдын 96% нь үзсэн байна. БОЭТ-ийн амбулаториор үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 84% ерөнхий сэтгэл ханамж маш сайн буюу сайн, 35% нь дунд гэж үнэлсэн байна.




## МЭС ЗАСЛЫН ТАСАГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

2. Эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш хэдий хугацааны дараа эмнэлэгт хэвтсэн бэ?




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 16 нь эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш 1-7 хоногийн дотор эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

3. Таны хэвтэн эмчлүүлж байгаа өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээг үнэлнэ үү.




Хэвтэн эмчлүүлэгчдийн 17 нь өрөө тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ маш сайн буюу сайн гэж үнэлсэн байна.

4. Таны хэвтэн эмчлүүлж байгаа өрөө, тасалгаа дулаан, тухтай эсэхийг үнэлнэ үү




Өрөөний дулаан тухтай байдлыг үнэлнэ үү гэсэн асуултад 16 нь маш сайн буюу сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.

5. Эмнэлгийн хоолны амт, чанарыг үнэлнэ үү.




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 16 нь эмнэлгийн хоолны амт чанар маш сайн буюу сайн байна гэж үнэлсэн бол 1 нь дунд зэрэг гэж үнэлсэн байна.

6. Эмч, сувилагч нар Тантай хүндэтгэлтэй харьцсан уу?




Эмч сувилагч нарын харилцаа хандлагын асуултад 17 нь маш сайн буюу сайн гэсэн үнэлгээтэй байна.

7. Сувилагч нар Танд хийж буй эмчилгээ, ажилбарын талаар ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү?



Хэвтэн эмчлүүлэгчдийн 16 нь маш сайн тайлбарлаж өгсөн гэж хариулсан бол 1 нь огт тайлбарлаж өгөөгүй гэж байна.


8. Танд эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авхуулсан эсэх?



Судалгаанд хамрагдсан хэвтэн эмчлүүлэгчдийн 15 нь эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авхуулаагүй гэж хариулсан бол 2 нь тийм гэж хариулсан байна.


Эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авсан гэж хариулсан хүмүүс нийт 60000 төгрөгний эм тариаг гаднаас авсан байна.

9. Эмнэлэгт хэвтэх хугацаанд Танд үзүүлж буй тусламж, үйлчилгээнд Та хэр сэтгэл хангалуун байгаа вэ?



Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 17 нь буюу 100% эмнэлэгт хэвтэх хугацааны ерөнхий сэтгэл ханамж маш сайн буюу сайн гэж хариулсан байна.


10. Танд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж, бэлэг авдаг эсэх?



Танд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж, бэлэг авдаг эсэх гэсэн асуултад 16 нь үгүй, 1 нь тийм гэж хариулсан байна.


## ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТАСАГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

2. Эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш хэдий хугацааны дараа э мнэлэгт хэвтсэн бэ?




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 17 нь эмч эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхийг зөвлөснөөс хойш 1-7 хоногийн дотор эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

3. Таны хэвтэн эмчлүүлж байгаа өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээг үнэлнэ үү.




Хэвтэн эмчлүүлэгчдийн 20 нь өрөө тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ маш сайн буюу сайн гэж үнэлсэн байна.

4. Таны хэвтэн эмчлүүлж байгаа өрөө, тасалгаа дулаан, тухтай эсэхийг үнэлнэ үү




Өрөөний дулаан тухтай байдлыг үнэлнэ үү гэсэн асуултад 20 нь маш сайн буюу сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.

5. Эмнэлгийн хоолны амт, чанарыг үнэлнэ үү.




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 18 нь эмнэлгийн хоолны амт чанар маш сайн буюу сайн байна гэж үнэлсэн бол 3 нь дунд зэрэг гэж үнэлсэн байна.

6. Эмч, сувилагч нар Тантай хүндэтгэлтэй харьцсан уу?




Эмч сувилагч нарын харилцаа хандлагын асуултад 20 нь маш сайн буюу сайн гэсэн үнэлгээтэй байна.

7. Сувилагч нар Танд хийж буй эмчилгээ, ажилбарын талаар ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү?



Хэвтэн эмчлүүлэгчдийн 20 нь маш сайн тайлбарлаж өгсөн гэж хариулсан бол 1 нь огт тайлбарлаж өгөөгүй гэж байна.


8. Танд эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авхуулсан эсэх?



Судалгаанд хамрагдсан хэвтэн эмчлүүлэгчдийн 18 нь эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авхуулаагүй гэж хариулсан бол 3 нь тийм гэж хариулсан байна.


Эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг гаднаас авсан гэж хариулсан хүмүүс нийт 11000 төгрөгний эм тариаг гаднаас авсан байна.

9. Эмнэлэгт хэвтэх хугацаанд Танд үзүүлж буй тусламж, үйлчилгээнд Та хэр сэтгэл хангалуун байгаа вэ?



Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 20 нь эмнэлэгт хэвтэх хугацааны ерөнхий сэтгэл ханамж маш сайн буюу сайн гэж хариулсан байна.

10. Танд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж, бэлэг авдаг эсэх?



Танд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж, бэлэг авдаг эсэх гэсэн асуултад 19 нь үгүй, 2 нь тийм гэж хариулсан байна.

-Төрөх гэж байгаа эмэгтэйчүүд тухайн эмч нарт мөнгө өгөх үзэгдэл хэвийн болсон. Энэ тал дээр цаашид анхаарах хэрэгтэй гэсэн санал гарсан.

### Судалгааны ерөнхий дүгнэлт

2023 оны 11-р сарын 22-ны өдөр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэс заслан тасгаар хэвтэн эмчлүүлж байгаа 17 иргэн, эх барих эмэгтэйчүүдийн тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 21 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Нийт судалгаанд хамрагдсан хэвтэн эмчлүүлэгчдээс тухайн хэвтэж буй өрөө тасалгааны цэвэрлэгээ,

дулаан тухтай байдлын талаарх асуултад 96% нь маш сайн буюу сайн гэж хариулсан бол 4% нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн. Эмнэлгийн хоолны амт чанарын асуултад 89% маш сайн буюу сайн, 11% нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн байна. Эмч сувилагч нарын харилцаа хандлагын талаарх асуултад 98% маш сайн буюу сайн, 2% нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн. Эмч сувилагч нарын эмчилгээ, ажилбар, эмийн эмчилгээнд гарч буй гаж нөлөөний талаарх асуултад 95% нь маш сайн тайлбарлаж өгсөн, 5% нь огт тайлбарлаж өгөөгүй гэж хариулсан. Эмчилгээ хийлгэхэд шаардлагатай эм тариаг 87% нь гаднаас авхуулаагүй гэж хариулсан. Танд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шан харамж, бэлэг авдаг эсэх талаарх асуултад 92% нь үгүй, 8% нь тийм гэж хариулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр хэвтэн эмчлүүлж байгаа судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн ерөнхий сэтгэл ханамж 98% нь маш сайн буюу сайн, 2% нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн байна.

Хэвтэн эмчлүүлэгчээс гарсан санал

-Төрөх гэж байгаа эмэгтэйчүүд тухайн эмч нарт мөнгө өгөх үзэгдэл хэвийн болсон. Энэ тал дээр цаашид анхаарах хэрэгтэй гэсэн санал гарсан.

#### Зөвлөмж

2023 оны 11-р сарын 13, 15, 22-ны өдрүүдэд БОЭТ-өөс хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллаа. Судалгаанаас харахад БОЭТ-ийн хэрэглэгчдийн сэтгэл ханамж өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаад талархаж байна. Тус судалгааны дүгнэлтийн дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

-2023 оны 11-р сарын 15-нь өдөр БОЭТ-ийн амбулаториор үйлчлүүлж байгаа 100 иргэнээс сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан. Судалгааны явцад иргэд эмчид үзүүлэхээр оочирлож байгаа үзэгдэл ажиглагдсан. Мөн судалгаанд хамрагдан иргэдийн 65% нь цахим бүртгэлээс авсан товлосон цагтаа үзүүлж чаддаггүй бөгөөд 10 минутаас 2 цаг орчим хүлээдэг гэж хариулсан байна. Хүлээлгийн хэсгийн орны тав тухтай байдалд судалгаанд хамрагдсан ирэдийн 59% нь дунд зэрэг гэж хариулсан байна. Иймд энэ 2 тал даар анхаарч ажиллана уу